



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2017 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А158

Улаанбаатар хот

“Эрүүл залуус” аяны удирдамжийг
хэрэгжүүлэн ажиллах тухай

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн заалт, Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар болон Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвтэй хамтрах санамж бичигт заагдсан заалтуудыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн хэмжээнд өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, амьдралын зөв дадлыг хэвшүүлж, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд салбар хоорондын хамтын ажиллагааг хангах “Эрүүл залуус” аяны хүрээнд хийх ажлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх хавсралтад заагдсан ажлуудыг төлөвлөсөн хугацаанд нь чанартай гүйцэтгэхийг холбогдох алба, тасаг нэгж, клиникүүдийн эрхлэгч нарт даалгасугай.

3. “Эрүүл залуус” аяны хүрээнд хийгдсэн ажлын тайланг 2017 оны 6, 12 дугаар сарын 01-ний дотор НЭМЭШСГХ-ны албанд ирүүлж байхыг холбогдох алба, тасаг нэгж, клиникүүдийн эрхлэгч нарт даалгасугай.

4. Нэгдсэн тайланг Нийслэлийн Эрүүл Мэндийн Газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтэст 2017 оны 6, 12 дугаар сарын 10-ний дотор явуулахыг НЭМЭШСГХ-ны албаны мэргэжилтэн К.Елена, Ж.Гантулга нарт хариуцуулсугай.

5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг НЭМЭШСГХ эрхэлсэн дэд захирал В.Баярмаад даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



В.НАСАНЦЭНГЭЛ

000418